



**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2023 оны 07 сарын 07 өдөр

Дугаар А/461

Арвайхээр сум

Эрх шилжүүлэх тухай


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 45 дугаар зүйлийн 45.6 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны “Аймгийн 2023 оны төсөвт тодотгол хийх тухай” 20/10 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтын 7 дахь заалтад тусгагдсан Баян-Өндөр сумын Эрчим хүчний шугам, дэд станцын өргөтгөлийн зардалд 60,000,000 (жаран сая) төгрөг зарцуулах эрхийг Баян-Өндөр сумын Засаг даргын Тамгын газарт шилжүүлсүгэй.

2. Худалдан авах ажиллагааг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу зохион байгуулж, үр дүн, хэрэгжилтийг тайлагнахыг Баян-Өндөр сумын Засаг дарга (С.Чулууншагай)-д үүрэг болгосугай.

3. Санхүүжилтийг хуваарийн дагуу олгохыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтэс (Ц.Идэрсайхан)-т зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



А.ИШДОРЖ

6223 11 0888

D:My Doc. Zahiramj. Zasag darga